



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/341

Номгон

Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл
ажиллагаа зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/54 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө"-ний 3.1.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хур тунадас нэмэгдүүлэх зорилгоор цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг 2023 оны 06 дугаар сард 2 удаа зохион байгуулсугай.

2.Дээрх үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах зардал 1,000,000 (Нэг сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, нутаг дэвсгэрийн чийгшлийн хэмжээг нэмэгдүүлж ажиллахыг Ус, цаг уур орчны шинжилгээний төв (Ч.Оюунчимэг)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

643310865